

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\130\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Реланс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 09/136
танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА З.ГАНТӨМӨР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.Т

Төв аймгийн Баянчандмань сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 95,4 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	ӨНГӨРСӨН ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	141,570,171.57	243,972,878.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	52,043,393.53	120,092,543.95
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	52,043,393.53	120,092,543.95
3121	Төгрөг	52,043,393.53	120,092,543.95
31211	Төрийн сангийн харилцах	52,043,393.53	120,092,543.95
33	АВЛАГА	741,215.75	16,692,554.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	741,215.75	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	16,692,554.00
35	БАРАА МАТЕРИАЛ	88,785,562.29	107,187,780.98
351	Түүхий эд материал	30,294,671.16	40,003,018.85
35110	Тусгай зориулалттай материал	6,511,140.00	7,504,740.00
35130	Эм боох материал	23,783,531.16	32,498,278.85
354	Хангамжийн материал	58,490,891.13	67,184,762.13
35410	Бичиг хэргийн материал	564,300.00	564,300.00
35420	Аж ахуйн материал	57,146,401.13	66,466,172.13
35460	Хүнсний материал	780,190.00	154,290.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	566,746,398.45	523,020,201.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	566,746,398.45	523,020,201.57
392	Биет хөрөнгө	558,034,398.44	514,426,201.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,197,006.00	460,197,006.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-74,764,373.20	-97,562,177.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	106,810,000.00	106,810,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,021,666.67	-73,474,666.75
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183,292,754.25	206,020,315.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,294,074.93	-105,626,314.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,527,330.00	34,447,330.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,496,410.42	-17,129,124.30
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,050,000.00	2,050,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,926,666.59	-1,966,666.55
39217	Ном	660,500.00	660,500.00
393	Биет бус хөрөнгө	8,712,000.01	8,594,000.05
39303	Бусад биет бус хөрөнгө	8,794,000.00	8,794,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-81,999.99	-199,999.95
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	708,316,570.02	766,993,080.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,901.54	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,901.54	00.00
413	Өглөг	1,901.54	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,901.54	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	708,314,668.48	766,993,080.50
51	Засгийн газрын хувь оролцоо	708,314,668.48	766,993,080.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	220,397,712.25	220,397,712.25
51101	Өмч: - төрийн	220,397,712.25	220,397,712.25
512	Хуримтлагдсан үр дүн	322,317,964.71	380,996,376.73
51210	Өмнөх үеийн үр дүн	322,317,964.71	322,317,964.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	58,678,412.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,598,991.52	165,598,991.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	708,316,570.02	766,993,080.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	738,986,848.15	874,393,168.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,026,746.76	55,094,544.83
120	Нийтлэг татварын бус орлого	113,026,746.76	55,094,544.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,311,223.86	21,220,247.81
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	372,387.00
120005	Түрээсийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	625,960,101.39	819,298,623.19
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,530,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,820,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	710,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,841,800.00	35,219,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,841,800.00	35,219,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	565,588,301.39	784,079,223.19
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	565,588,301.39	784,079,223.19
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	655,306,757.38	798,939,762.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,306,757.38	798,939,762.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650,126,391.38	788,939,762.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,139,664.04	465,086,807.37
210101	Үндсэн цалин	212,878,548.86	254,550,018.75
210102	Нэмэгдэл	149,139,963.59	168,243,084.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,391,806.00	4,504,000.00
210104	Урамшуулал	28,729,345.59	37,789,704.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,545,311.00	56,974,999.61
210201	Тэтгэврийн даатгал	35,402,211.00	40,446,946.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,285,800.00	4,776,333.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,628,800.00	3,826,905.67
210204	Ажилгүйдлийн даатгал	657,100.00	720,437.68
210205	Эрүүл мэндийн даатгал	6,571,400.00	7,204,376.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,497,862.00	34,069,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,782,462.00	5,563,600.00
210302	Түлш, халаалт	22,334,400.00	28,124,800.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,762,634.00	49,902,175.00
210401	Бичиг хэрэг	2,367,634.00	4,634,200.00
210402	Тээвэр, шатахуун	27,409,900.00	39,420,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,725,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,485,100.00	4,122,375.00
2105	Нормативт зардал	51,081,877.11	59,826,939.59
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,545,004.61	45,293,139.59
210502	Хоол, хүнс	11,536,872.50	14,533,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,931,420.00	39,067,670.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,243,260.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,895,120.00	3,321,010.00
210604	Урсгал засвар	10,036,300.00	34,503,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,978,000.00	2,408,000.00
210702	Дотоод албан томилолт	1,978,000.00	2,408,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	809,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	380,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	50,000.00
210807	Газрын төлбөр	00.00	29,500.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,189,623.23	80,794,270.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,056,149.29	10,441,213.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,133,473.94	70,353,057.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,180,366.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10,000,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,180,366.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,180,366.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	83,680,090.77	75,453,405.76
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,690,185.88	16,774,993.74
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,690,185.88	16,774,993.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-20,690,185.88	-16,774,993.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62,989,904.89	58,678,412.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	699,717,101.39	803,606,069.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	699,717,101.39	802,606,069.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,287,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,577,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	710,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,841,800.00	35,219,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,841,800.00	35,219,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	565,588,301.39	767,386,669.19
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	565,588,301.39	767,386,669.19
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	634,055,579.04	729,777,918.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,055,579.04	729,777,918.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,875,213.04	719,777,918.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,139,664.04	464,975,106.16
210101	Үндсэн цалин	212,878,548.86	253,922,405.75
210102	Нэмэгдэл	149,139,963.59	168,758,996.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,391,806.00	4,504,000.00
210104	Урамшуулал	28,729,345.59	37,789,704.18

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,545,011.00	56,974,999.61
210201	Тэтгэврийн даатгал	35,402,211.00	40,446,946.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,285,800.00	4,776,333.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,628,500.00	3,826,905.67
210204	Ажилгүйдлийн даатгал	657,100.00	720,437.68
210205	Эрүүл мэндийн даатгал	6,571,400.00	7,204,376.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,331,434.00	34,069,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,881,634.00	5,563,600.00
210302	Түлш, халаалт	23,068,800.00	28,124,800.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,909,434.00	49,424,000.00
210401	Бичиг хэрэг	2,499,534.00	4,374,700.00
210402	Тээвэр, шатахуун	27,409,900.00	39,499,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,725,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,825,300.00
2105	Нормативт зардал	75,995,609.00	65,299,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,988,809.00	51,391,200.00
210502	Хоол, хүнс	17,006,800.00	13,907,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,143,700.00	36,944,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,813,700.00	1,794,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	3,750,300.00
210604	Урсгал засвар	15,330,000.00	31,400,300.00
2107	Томилот, зочны зардал	1,978,000.00	2,380,000.00
210702	Дотоод албан томилот	1,978,000.00	2,380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	809,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	380,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	50,000.00
210807	Газрын төлбөр	00.00	29,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,832,361.00	8,901,213.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,832,361.00	8,901,213.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,180,366.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,180,366.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,180,366.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	65,661,522.35	73,828,150.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,221,390.00	5,779,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,221,390.00	5,779,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,221,390.00	5,779,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,221,390.00	5,779,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-16,221,390.00	-5,779,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	49,440,132.35	68,049,150.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,603,261.18	52,043,393.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,043,393.53	120,092,543.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	172,653,598.99	-96,292,534.35	296,758,776.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,397,712.25	172,653,598.99	-96,292,534.35	296,758,776.89
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,102,658.15	-11,102,658.15
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	322,317,964.71	708,314,668.48
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	322,317,964.71	708,314,668.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	322,317,964.71	708,314,668.48
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	58,678,412.02	58,678,412.02
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	380,996,376.73	766,993,080.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	802,113,000.00	736,184,531.77	-65,928,468.23	91.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	802,113,000.00	736,184,531.77	-65,928,468.23	91.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,113,000.00	726,184,531.77	-65,928,468.23	91.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,979,600.00	465,602,719.16	-81,376,880.84	85.1
210101	Үндсэн цалин	384,246,000.00	254,550,018.75	-129,695,981.25	66.2
210102	Нэмэгдэл	77,969,300.00	168,758,996.23	90,789,696.23	216.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,762,800.00	4,504,000.00	-258,800.00	94.6
210104	Урамшуулал	28,067,300.00	37,789,704.18	9,722,404.18	134.6
210105	Гэрээт ажлын хөлс	51,934,200.00	00.00	-51,934,200.00	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ	62,594,100.00	56,974,999.61	-5,619,100.39	91.0
210201	Тэтгэврийн даатгал	42,565,800.00	40,446,946.26	-2,118,853.74	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,008,100.00	4,776,333.44	-231,766.56	95.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,005,000.00	3,826,905.67	-178,094.33	95.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,000,100.00	720,437.68	-279,662.32	72.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,015,100.00	7,204,376.56	-2,810,723.44	71.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	34,069,400.00	34,069,400.00	
210301	Гэрэл, цахилгаан	00.00	5,563,600.00	5,563,600.00	
210302	Түлш, халаалт	00.00	28,124,800.00	28,124,800.00	
210303	Цэвэр, бохир ус	00.00	381,000.00	381,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	49,424,000.00	49,424,000.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,374,700.00	4,374,700.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	39,499,000.00	39,499,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,725,000.00	1,725,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,825,300.00	3,825,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	65,299,100.00	65,299,100.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,391,200.00	51,391,200.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	13,907,900.00	13,907,900.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,500,300.00	40,953,600.00	453,300.00	101.1

210601	Багаж, техник, хэрэгсэл	6,499,700.00	5,803,000.00	-696,700.00	89.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,750,300.00	3,750,300.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	30,250,300.00	31,400,300.00	1,150,000.00	103.8
2107	Томилолт, зочны зардал	3,095,700.00	2,380,000.00	-715,700.00	76.9
210702	Дотоод албан томилолт	3,095,700.00	2,380,000.00	-715,700.00	76.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хууль	809,500.00	809,500.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	380,000.00	380,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	29,500.00	29,500.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23410700.00	10671213.00	-12,739,487.00	45.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,410,700.00	10,671,213.00	-12,739,487.00	45.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10000000.00	10000000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	802,113,000.00	803,606,069.19	1,493,069.19	100.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	35,219,400.00	35,219,400.00	
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	35,219,400.00	35,219,400.00	
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	749,069,700.00	767,386,669.19	18,316,969.19	102.4
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	749,069,700.00	767,386,669.19	18,316,969.19	102.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	53,043,300.00	1,000,000.00	-52,043,300.00	1.9
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	52,043,300.00	00.00	-52,043,300.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	52,043,393.53	52,043,393.53	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	120,092,543.95	120,092,543.95	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00	57,281.00	5715.8
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00	7,323.00	1419.5
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	4,090.00	998.9
620003	Үйлчлэх ажилтан	10.00			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Эх хүүхдийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 3 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь батлагдсан 27, гүйцэтгэлээр 23 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 93,2 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 82,9 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,676,5 мянган төгрөгөөр буюу 8,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	52,043,4	120,092,5	68,049,1
Авлага	741,2	16,692,5	15,951,3
Урьдчилгаа			
Бараа материал	88,785,6	107,187,8	18,402,2
Үндсэн хөрөнгө	566,746,4	523,020,2	(34.726.2)
Нийт хөрөнгө	708,316,6	766,993,1	58.676.5
Өр төлбөр	1,9		1.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн	708,314,7	766,993,1	58.678.4

өмч/			
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	708,316,6	766,993,1	58.678.4

Дээрх хүснэгтээс харахад: 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 68,049.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь мөнгөн гүйлгээний орлого болон эхний үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 16,692.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,951.3 мянган төгрөгөөр өссөн нь 2023 оны эцэст Нийгмийн даатгалын сангаас авах авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 18,402.2 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 145,878.2 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн бараа материал худалдан авсан.
- Хандиваар 33,181.9 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл, боох материал үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Бараа материал данснаас байгууллагын үйл ажиллагаанд 161,315.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 523,020.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,726.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгө дансны элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 5,779.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр, 15,620.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар тус тус худалдаж авсан.
- 5,227.3 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан.
- 2023 онд 3,979.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга хэрэгслийг акталж устгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 801,113.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 35,219.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 837,332.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 837,332.4 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг 837,332.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 766,893.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 35,219.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 802,113.0 мянган төгрөг байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 736,184.5 мянган төгрөг буюу 91,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 65,928.4 мянган төгрөгөөр, үүнээс цалин нэмэгдэл, урамшуулал 81,376.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,739.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Мөн байр ашиглахтай холбоотой зардлыг 34,069.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71802 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80302	Үндсэн үйл ажиллагааны зардал 1 иргэн	523,613.5	499,523.2	24,090.3	95,4
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	225,456.2	214,044.7	11,411.5	94,9
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	35,219.4	35,219.4		100
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	52,043.3	49,351.8	2,691.5	94,8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80302	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны зардал	95,4	523,613,5	499,523,2
2	71802-81603	2023-12-31	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	94,9	225,456,2	214,044,7
3	71802-83603	2023-12-31	Дээд шатны төсвөөс хуваарилсан	94,8	52,043,3	49,351,8
4	71802-80111	2023-12-31	Төрийн өмчийн байр ашиглалт	100,0	35,219,4	35,219,4

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг. Хүнсний бараа материалыг сумын худалдан авах ажиллагааны тендерт бүртгэгдсэн компаниас авдаг байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 645,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 12,900.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,600.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 3 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 81,376.8 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 12,739.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 155 мэдээллийг байршуулж 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад зардлын данстай холбоотой 274.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1				
Албан шаардлага	3	2,858.0	3	2,858.0	100
Зөвлөмж	3	16,184.4	3	16,184.4	100
Нийт дүн	4	19,042.4	4	19,042.4	100

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрийн дугаараар бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 184.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 184.0 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Тэтгэвэр тогтоолгосон иргэнийг ажилд аван цалинжуулж ээлжийн амралт олгохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109.9, 109.6 дугаар заалт, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ, хэлэлцээрүүдийн заалтыг харгалзан тооцож амралтын хөлсийг олгоогүй 184.0 мянган төгрөгний зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт:

2023 оны 05 дугаар сард мөнгөн гүйлгээний тайланг шалгахад 190.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал гарсан боловч анхан шатны нотлох баримт огт байхгүй байв. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д заасан “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” санхүүгийн тайлангийн “ иж бүрэн байх”, Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан” Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Холбогдох Хууль тогтоомжийн дагуу ээлжийн амралтыг тооцоогүй	1	184,0					1	184,0				
Дүн	1	184,0					1	184,0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Анхан шатны бүртгэлтэй холбоотой	1	190.0	1	190.0								
Дүн	1	190.0	1	190.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn